**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 06 сарын 29 өдөр Дугаар А/300 Чингис хот

Үерийн эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1. 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь хэсэг, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн үерийн эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Д.Элбэгсайхан | Аймгийн онцгой комиссын нарийн бичгийн дарга, Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч Дэд хурандаа |
| Нарийн бичиг: | Т.Мөнхчимэг | Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, хариуцсан мэргэжилтэн Дэслэгч |
| Гишүүд | Ц.Идэрбат | Чингис хотын захирагч бөгөөд Хэрлэн сумын Засаг дарга |
| | Э.Мөнх-Эрдэнэ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| | Д.Баярхүү | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга |
| | Б.Мөнх-Эрдэнэ | Байгаль орчин, аялал, жуулчлалын газрын Уул уурхай нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн |
| | Г.Мөнхсайхан | Ус цаг уур орчны шинжилгээний төвийн Мэдээлэл, үйлчилгээний хэлтсийн дарга |
| | Г.Мөнхсайхан | Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч |

| | | |
|---|---|---|
| | | 2. |
| | Г.Мөнхзул | Онцгой байдлын газрын Төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч Дэд хурандаа |

2. Үерийн эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаан хийж дуусгахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлд танилцуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын орлогч дарга /дэд хурандаа П.Элбэгсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Н.ГАНБЯМБА